



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар Д/166

Хэрлэн сум

“Шүүр” ажиллагааг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оны “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд аймгийн хэмжээнд “Шүүр” ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | | |
|--------------------------|----------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Дарханбаатар | Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Т.Бямбадулам | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн |
| | С.Лхагвацэрэн | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн төрийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд: | Л.Цэнддорж | Цэргийн штабын дарга, офицер |
| | Д.Мягмарбаатар | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн |

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж үр дүнг 2023 оны 4 дүгээр сарын 06-ны дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Дарханбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010449